



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-ПЛН-0001-М	Хувилбар: 1.1

1. ТАНИЛЦУУЛГА	5
1.1. БАРИМТ БИЧГИЙН ДУГААР	5
1.2. ЗОРИЛГО.....	5
1.3. ХЭРЭГЛЭЭ.....	5
1.4. ЭХЛЭХ ОГНОО	5
1.5. ЭРХ МЭДЭЛ БА УДИРДЛАГА.....	5
2. ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1. УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.2. БУСАД УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ДАВХЦАХ БАЙДАЛ.....	5
3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	6
3.1. УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	6
3.2. Гол уялдаа холбоо	7
4. ТӨСЛИЙН СТАНДАРТ	7
4.1. Монгол улсын холбогдох хууль, стандартууд.....	7
4.2. БОНБНҮ-ийн шаардлагууд	8
4.3. МУ-ын ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН БУСАД ҮҮРЭГ АМЛАЛТ, ШААРДЛАГУУД.....	8
4.4. Холбогдох олон улсын стандарт болон удирдамжууд	8
4.5. Рио Тинто компанийн холбогдох стандартууд.....	9
4.6. Хог хаягдлын удирдлагын ерөнхий аргачлал	9
5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД	10
6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ	14
6.1. УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ ШИНЭЧЛЭЛ	14
7. МОНИТОРИНГ	14
7.1. МОНИТОРИНГИЙН ШААРДЛАГЫН ТОЙМ.....	14
7.2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ	14
7.3. МОНИТОРИНГИЙН ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	15
8. СУРГАЛТ	18
8.1. Тойм.....	18
8.2. ТАНИЛЦУУЛГА СУРГАЛТ.....	18
8.3. Ажлын байран дахь тусгай сургалт	18
8.4. СУРГАЛТЫН БУСАД ШААРДЛАГУУД.....	18
9. АУДИТ БОЛОН ТАЙЛАН	19
9.1. Дотоод аудит.....	19
9.2. Гадаад аудит.....	19
9.3. БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТ	19
10. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ	20
ХҮСНЭГТҮҮД	
Хүснэгт 1. Гол хариуцагчид болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг	6
Хүснэгт 2. Удирдлагын гол хяналтууд.....	11
Хүснэгт 3. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	14
Хүснэгт 4. Мониторингийн гол хэмжилтүүд.....	16

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. Баримт бичгийн дугаар

Энэ бичиг баримт нь Оюу Толгой (ОТ) төслийн Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө болно. Энэ удирдлагын төлөвлөгөөний бичиг баримтын дугаар нь ОТ-10-Е7-PLN-0001.

1.2. Зорилго

Энэ удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын холбогдох нэгжүүдийн уялдаа холбоог харуулах;
- ажлын байрны үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн холбогдох стандартууд, удирдамжуудыг тоймлон гаргах;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн үүрэг даалгавар, үйл ажиллагааны журам, удирдамжийг тодорхойлж, энэ төлөвлөгөөнд тусгагдсан Оюу Толгой компанийн Байгаль орчны бодлогын шаардлагуудыг тодруулах;
- Гүйцэтгэлийн Гол Үзүүлэлт (ГҮҮ)-ийг багтаасан мониторингийн болон тайлагналтын журмыг тодорхойлох;
- Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ба
- Холбогдох материал болон мэдээллийн лавлагааг тусгах болно.

1.3. Хэрэглээ

Энэ удирдлагын төлөвлөгөөнд заасан шаардлагууд нь Оюу Толгой компанийн болон гэрээт компаниудын бүх үйл ажиллагаанд хамааралтай болно.

Энэ удирдлагын төлөвлөгөө нь Рио Тинто компанийн 2008 онд гаргасан *Е7-Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын стандартад* үндэслэгдэн боловсруулагдсан болно. Рио Тинто компанийн *Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын стандартад* оруулах аливаа өөрчлөлтөөс шалтгаалан Оюу Толгой компанийн энэхүү удирдлагын төлөвлөгөө өөрчлөгдөж болно. Мөн, энэ Удирдлагын Төлөвлөгөө нь хоёр жил тутамд дахин хянагдан шинэчлэгдэж байх ба төслийн төлөвлөлт, журманд орсон өөрчлөлт бүр энэ Удирдлагын төлөвлөгөөнд тусгагдаж байна.

1.4. Эхлэх огноо

Энэ удирдлагын төлөвлөгөө 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болно.

1.5. Эрх мэдэл ба удирдлага

Оюу Толгой компанийн Гүйцэтгэх хороо энэ удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр баталсан.

Оюу Толгой компанийн ЭМААБО-ны хэлтсийн ерөнхий менежер энэ удирдлагын төлөвлөгөөний гол хариуцагч нь байна. Энэ удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг энэ албан тушаалтанд тавих ба тухайн саналыг зохих байдлаар хянан үзсэний гол дээр өөрчлөлт хийх эсэхийг шийдвэрлэнэ.

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэ удирдлагын төлөвлөгөө Оюу Толгойн гол болон гэрээт гүйцэтгэгчдийн бүх үйл ажиллагаанд хамаарна.

Энэ төлөвлөгөөний гэрээт гүйцэтгэгчдийн хэрэгжүүлэх хэсгийг Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын хэсэгт тусгасан болно (лав: ОТ-07-PLN-0001).

Эрдсийн бус хог хаягдлын тодорхойлолт

Энэ төлөвлөгөөний зорилгоор эрдсийн бус хог хаягдлыг дараахь байдлаар тодорхойлсон. Үүнд:

ашигласан тос, антифриз, тосолгооны материал, аккумулятор, батерей, уусмал, хөргөгч бодис, химийн урвалж бодис, будаг, дугуй, бохирдсон хөрс, элдэв хаягдал, бохир ус зайлуулах суваг шуудууны хатуу хог үлдэгдэл, барилгын хог хаягдал мөн үйлдвэрлэлд ашигласан тодорхойлон заагаагүй түүхий эд (хүдрээс бусад) зэргийг оролцуулан үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, эмнэлэгийн байгууламж, хоолны газар, офис, цех, лаборатори, цэцэрлэгийн хог хаягдал зэргийг оролцуулсан боловч эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Эрдсийн бус хог хаягдалд уурхайн чулуулаг болон сул тунамал чулуулыг баяжуулах үйл ажиллагаанаас шууд гарсан хог үлдэгдлийг оруулахгүй болно.

2.2. Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэ удирдлагын төлөвлөгөө нь Оюу Толгойн Байгаль орчин, Нийгмийн Удирдлагын Төлөвлөгөө (БОНМТ)-ний ерөнхий бүтцэд тодорхойлогдсон төслийн Ашиглалтын шатны удирдлагын багц төлөвлөгөөний нэг хэсэг юм. (ОТ-10-PLN-0003).

Энэ удирдлагын төлөвлөгөө нь дараах удирдлагын төлөвлөгөөнүүдтэй давхцах буюу харилцан холбоотой байдлаар боловсруулагдсан. Үүнд;

- Аюултай материалын удирдлагын төлөвлөгөө (лав: ОТ-10-Е5-PLN-0001), ялангуяа аюултай хог хаягдлын удирдлагатэй холбоотойгоор;
- Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (лав: ОТ-10-Е8-PLN-0001), ялангуяа, болзошгүй бохирдлын мониторингтэй холбоотойгоор;
- Усны эх үүсвэр, нөөцийн удирдлагын төлөвлөгөө (лав: ОТ-10-Е10-PLN-0001), ялангуяа, болзошгүй бохирдлын мониторингтэй холбоотойгоор;
- Агаарын хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (лав: ОТ-10-Е2-PLN-0001), ялангуяа, Хог хаягдлын удирдлагын төвд байрлах аюултай хог хаягдлыг шатаах байгууламжаас гарах хийн хаягдлын удирдлага болон мониторингтэй холбоотойгоор.

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1. Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол үүрэг хариуцлага

Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтнууд болон тэдний үүрэг хариуцлагыг доорх байдлаар тоймлон харуулав.

Хүснэгт 1. Гол хариуцагчид болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

Хариуцагч	Гүйцэтгэх үүрэг
ЭМААБО хариуцсан ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> Нийт төлөвлөгөөний хамрах хүрээ болон хэрэгжилтийг хариуцна. Төслийн стандарт болон энэ төлөвлөгөөнд тусгагдсан бусад шаардлагуудын хэрэгжилтийг хангуулах.
Байгаль орчны менежер	<ul style="list-style-type: none"> Энэ удирдлагын төлөвлөгөөг ерөнхийд нь хариуцан хэрэгжүүлэх. Хог хаягдлын удирдлагын төвийн хаягдал булшлах байгууламж болон хаягдал дахин боловсруулах үйл ажиллагааны удирдлагын хяналт. Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмын хэрэгжилттэй холбоотойгоор Оюу Толгойн хэлтсийн менежерүүд болон гол гэрээт гүйцэтгэгч нарт техникийн туслалцаа үзүүлэх. Хог хаягдлын үйл ажиллагааг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан улирлын болон жилийн байгаль орчны тайланг бэлтгэх. Нийт хаясан болон дахин ашигласан хог хаягдлын бүртгэл мэдээллийг гаргаж, харьцуулах. Төлөвлөгөө Оюу Толгойн гол болон гэрээт нийт ажилчдын хүртээл болсон эсэхийг нягтлах. Энэ удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмын шаардлагыг хэрхэн биелүүлж байгааг тодорхойлох үзлэг шалгалт, аудитыг Оюу Толгойн бүх хэлтэс болон гол гэрээт гүйцэтгэгчдийн ажлын байруудад хийж гүйцэтгэх. Бүх аюул, зөрчил болон осол тохиолдлыг мэдээлэх.
Оюу Толгойн дэд бүтцийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> Аюулгүй хог хаягдлыг булшлах байгууламж болон аюултай хог хаягдлыг шатаах байгууламж гэх мэт Хог хаягдлын удирдлагын төвийн үйл ажиллагааны удирдлагын хяналт.
Оюу Толгойн бусад хэлтэс болон гол гэрээт гүйцэтгэгч	<ul style="list-style-type: none"> Энэ удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмын дагуу холбогдох үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд анхаарах. Хэлтсийн ажилтнууд хог хаягдлын удирдлагын үйл ажиллагаанд, ялангуяа аюултай материал, бодистой ажиллахад бүрэн сургалтанд хамрагдсан эсэхэд анхаарах. Осол, зөрчлийн тохиолдлыг магадлан шинжилж тайлагнахад анхаарах.
Ажлын байрны ЭМААБО хариуцсан ахлах ажилтнууд / орлогч дарга	<ul style="list-style-type: none"> Энэ удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг шалгах ажлын байрны тогтмол үзлэг шалгалтыг явуулах. Хог хаягдлын бүх өгөгдөл мэдээллийг зохих ёсоор бүртгэж, мэдээлж байхад анхаарах. Бүх аюул, зөрчлийг болон осол тохиолдлыг мэдээлэх.

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

3.2. Гол уялдаа холбоо

Энэ удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол нэгжүүдэд (өөрөөр хэлбэл энэ удирдлагын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэгчдэд) дараах хэлтсүүд орж байна.

- Дэд бүтцийн хэлтэс болон ажлын байрны менежерүүд, ялангуяа ажлын байрны хог хаягдлыг цуглуулан Хог хаягдлын удирдлагын төв рүү дамжуулахтай холбоотойгоор.
- Дэд бүтцийн болон байгаль орчны хэлтэс, ялангуяа хог хаягдлын ачилтын мэдээлэл болон хогийг дахин ашиглах, Хог хаягдлын удирдлагын төвийн хаягдал булшлах байгууламж болон хаягдал шатаах зуухны үйл ажиллагаатай холбоотой өгөгдөл мэдээллийг цуглуулахтай холбоотойгоор.
- Ажлын байрны хог хаягдлыг ангилан ялгах зэрэг хог хаягдлыг зохистой, үр дүнтэй байдлаар цуглуулж, ачихтай холбоотойгоор бүх үйл ажиллагаа явуулж байгаа хэлтсүүд болон гол гэрээт гүйцэтгэгчид.

4. ТӨСЛИЙН СТАНДАРТ

Төслийн бүх үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг ("Төслийн стандартууд") баримтлах ёстой. Төслийн стандартуудад дараах стандартууд орж байна.

- Монгол улсын холбогдох хуулиуд болон үндэсний стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-ний шаардлага;
- Монгол улсын Засгийн газар, түүний хэрэгжүүлэгч агентлагуудын шаардлага болон үүрэг даалгаварууд;
- Зээлдүүлэгчийн холбогдох стандарт, удирдамж;
- Рио Тинто компанийн холбогдох стандартууд;
- Оюу Толгой компанийн мөрдөх ёстой аж үйлдвэрийн салбарын бусад удирдамжууд.

4.1. Монгол улсын холбогдох хууль, стандартууд

Хог хаягдлын удирдлагатай холбоотой Монгол улсын хууль, үндэсний стандартуудыг доор үзүүлэв. Үүнд:

- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадглах, дахин ашиглах, болон булшлахтай холбоотой есуудлыг зохицуулсан 2012 оны Монгол улсын Хог хаягдлын тухай хууль. Хог хаягдал нь: а) ахуйн хог хаягдал болон б) аюултай хог хаягдал (хүн, амьтны эрүүл мэнд болон байгаль орчин сөрөг нөлөөтэй) гэж ангилдаг. Аюултай хог хаягдал нь тодорхой тоног төхөөрөмж, технологийн дагуу зориулалтын Хог хаягдлын удирдлагын төвд боловсруулагдаж байх ёстой. Энэхүү хуулиар хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах асуудлыг дэмжиж өгсөн. Хог хаягдлыг дахин ашиглах болон дахин боловсруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж нь эцсийн бүтээгдэхүүнийг зарж борлуулах эрхийг эдэлдэг. Аймгийн засаг дарга нь хог хаягдал боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгжийн хаягдлын удирдлагийг хянан үздэг.
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2006 онд батлагдсан (2011 онд нэмэлт тодотгол хийсэн) бөгөөд химийн болон аюултай бодисыг экспортлох, импортлох, тээвэрлэх, хадгалах, ашиглах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн. Тус хуулиар хортой, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөн тодорхойлон заасан болно.
- 1998 боловсруулж, 2011 онд нэмэлт тодотгол хийгдсэн Ариун цэврийн тухай хууль нь иргэн, аж ахуйн нэгжийн хөрсний эрүүл ахуй, хог устгах болон хаягдал шингэн зайлуулах байгууламж, муу усны нүх, бие засах газар, эмнэлгийн хаягдал, радио идэвхт болон химийн хорт бодисын талаарх үүрэг хариуцлагуудыг тодорхойлсон.

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

- Аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, тээвэрлэх, боловсруулах, хадгалах, устгах журмыг баталсан 2002 онд гарсан Засгийн газрын 135 дугаар тогтоол.
- 2011 оны Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хаях журмыг баталсан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрүүл мэндийн яамны сайдын хамтарсан А-320/305 тоо тушаал.
- Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын журмыг баталсан Байгаль орчны яамны сайдын 2006 оны 404 дүгээр тушаал.

4.2. БОНБНУ-ийн шаардлагууд

Оюу Толгой төслийн БОНБНУ-д хог хаягдлын удирдлагатэй шууд холбоотой тодорхой заалтууд байхгүй болно. БОНБНУ-ний нэг бүрдэл хэсэг болсон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд багтсан Хог хаягдлын удирдлага болон мониторингийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг энэ удирдлагын төлөвлөгөөнд тусган оруулсан болно.

4.3. МУ-ын Засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, шаардлагууд

Монгол улсын засгийн газрын шаардлагад нийцүүлэх зорилтыг тусгасан гол бичиг баримт бол Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ (2009 оны 10 дугаар сарын 6) болно. Зургадугаар бүлгийн (Байгаль орчин) 6.4,6.9,6.10-р зүйлүүдийг Оюу Толгойн хог хаягдлын удирдлагатэй ерөнхийдөө хамааралтай байна. Эдгээр заалтууд нь:

- Хөрөнгө оруулагч нь Оюу Толгой төслийн хэрэгжилттэй холбоотой Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /цаашид “**БОХТ**” гэх/, орчны мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах жил бүрийн бүх зардлыг хариуцах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд дурдсан арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаа тухай хараат бус, мэргэшсэн, эрх бүхий гадаад шинжээчийн тайланг 3 /гурав/ жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Хөрөнгө оруулагч нь гол үйл ажиллагаатайгаа холбоотой байгаль орчны шинжилгээ, мониторингийн иж бүрэн үнэлгээний хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Байгаль орчны мониторингийн хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа бодит сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд эрдсийн бус хог хаягдлын удирдлагийг онцлон заасан шаардлага байхгүй болно.

4.4. Холбогдох олон улсын стандарт болон удирдамжууд

Дараахь олон улсын тэргүүн туршлагын удирдамж болон хууль тогтоомжуудыг баримталдаг болно. Үүнд:

- ОУСК-ын Уул уурхайн салбарын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамж 2007 он;
- ОУСК-ын Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий удирдамж, 2007 он;
- ОУСК-ын Үйл ажиллагааны стандарт 3 - Бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах (2012 оны 1 дүгээр сар); ба
- ЕСБХБ-ын үйл ажиллагаанд тавигдах шаардлага (ялангуяа ГҮ1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон удирдлага ГҮ3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх болон бууруулах).

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

Оюу Толгойн талбай дахь хог хаягдлын удирдлагын байгууламжийн зураг төсөл болон үйл ажиллагааг дараахийг оролцуулан Европын холбооны болон олон улсын хог хаягдлын удирдлагын стандартуудад нийцэхээр боловсруулсан болно. Үүнд:

- Европын холбооны удирдамж № 99/31/ЕС, 1999 он (хог хаягдлыг булшлах талаар);
- Европын холбооны удирдамж № 2000/76/ЕС, 2000 оны 12 дугаар сарын 4 (хог хаягдлыг шатаах талаар);
- ДЭМБ-ын хог хаягдлын аюулгүй удирдлага: Бодлогын бичиг болон баримтын товчоон № 281, (хог хаягдлын удирдлага эрүүл ахуй);
- Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай конвенц (Базелийн конвенц, Монгол улс 1997 онд баталсан); ба
- АНУ-ын байгаль орчныг хамгаалах агентлагын Холбооны улсын зохицуулалтын хууль 258 (Хотын хатуу хог хаягдлыг булшлах байгууламжид тавигдах шаардлага), хог хаягдлыг шатаах болон булшлах байгууламжинд тавигдах тодорхой шаардлагыг доор үзүүлэв.

4.5. Рио Тинто компанийн холбогдох стандартууд

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагаэд хамаарах Рио Тинтогийн гол стандарт бол 2008 оны *E7 – Эрдсийн бус хог хаягдлын удирдлага* болно.

Бусад холбогдох Рио Тинто компанийн стандарт болон удирдамжинд доорх зүйлс орно. Үүнд:

- E2 Агаарын чанарын хяналтын стандарт;
- E5 Аюултай материал болон бохирдлын хяналтын стандарт;
- E8 Эрдэст хаягдлын удирдлагын стандарт;
- E9 Газар ашиглалтын төлөвлөлтийн стандарт.

4.6. Хог хаягдлын удирдлагын ерөнхий аргачлал

Энэ удирдлагын төлөвлөгөөний зорилт бол хог хаягдал үүсэхийг хамгийн бага хэмжээнд байлгах, үүссэн хог хаягдалтай аюулгүй харьцах, боловсруулах, зайлуулах замаар Оюу Толгойн эрдсийн бус хог хаягдлын үр дүнтэй удирдлагаийг хэрэгжүүлэх явдал юм. Энэ зорилтонд Хог хаягдлын шаталсан удирдлагаийг хэрэгжүүлэх замаар хүрнэ. Үүнд:

- хог хаягдлын эх үүсвэрийг хамгийн бага хэмжээнд байлгаж, хог хаягдал үүсэхээс зайлсхийх;
- хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах;
- хог хаягдлыг дахин ашиглаж; улмаар
- олон улсын стандартын дагуу хог хаягдлыг хадгалж, боловсруулан хаях.

Үйл ажиллагаанд хэрэглэгдэх боломжтой, хамгийн бага материал бүхий савлагаатай бүтээгдэхүүн нийлүүлэх ханган нийлүүлэгчийг сонгох болон бараа бүтээгдэхүүнийг хугацааг нь дуусахаас нь өмнө ашиглаж, хэрэглэхийг хянадаг нарийн удирдлагаийг хэрэгжүүлэх замаар хог хаягдлыг бууруулах болон үүсэхээс зайлсхийнэ.

Орон нутагтай хамтран ажиллах болон үнэлэгээ хийлгэж, зохих тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлыг дахин ашиглагч гэрээт гүйцэтгэгчтэй хамтран ажиллах замаар хог хаягдлыг дахин ашиглах ажлыг хэрэгжүүлнэ.

Зөвшөөрөгдсөн аюулгүй хог хаягдлыг булшлах байгууламж болон аюултай хог хаягдлыг шатаах зуух бүхий уурхайн талбайн хог хаягдлын удирдлагын төвд хог хаягдлыг боловсруулж, зайлуулна.

Эрдсийн бус Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД

Энэ Удирдлагын төлөвлөгөө нь Оюу толгой төслийн талбайд хог хаягдлын удирдлагын үйл ажиллагаатай хобоотой нарийвчилсан мэдээллийг агуулсан доорх журмуудаар хүрээгээ нэмсэн байна. Үүнд:

- Оюу толгойн ажлын байруудад хаягдал цуглуулах, тээвэрлэх туршлагатай холбоотой Ердийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх журам (ОТ-10-Е7-PRC-0002),
- Хог хаягдлын удирдлагын төв дэх аюулгүй, хатуу хаягдлыг зайлуулах, аюултай хаягдлыг шатаах болон дахин өоловсруулах үйл ажиллагааны туршлагатай холбоотой Хог хаягдлын удирдлагын төвийн ажиллуулах журам (ОТ-10-Е7-PRC-0001).

Энэхүү эрдсийн бус хаягдлын Удирдлагын төлөвлөгөөнд шаардлагатай бусад журмуудыг шаардлагатай тохиолдолд боловсруулж болно.

Оюу Толгой төслийн эрдсийн бус хог хаягдалд тавигдах гол удирдлагын хяналтыг доор хураангуйлан үзүүлэв.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

Хүснэгт 2. Удирдлагын гол хяналтууд

№	Сэдэв/ талууд	Хэрэглээ/ үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулалт
WM01	Хог хаягдлын шатлал	<p>Хог хаягдлын удирдлагын шатлалын зарчмыг энэ хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмыг хэрэгжүүлэх үед дараах дэс дараалаар ашиглаж болно. Үүнд.</p> <p>a) Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж үүсэхээс зайлсхийх;</p> <p>b) Хог хаягдлын дахин ашиглалт болон дахин боловсруулалт; ба</p> <p>c) Хог хаягдлын хадгалалт, боловсруулалт болон зайлуулалт.</p>	<ul style="list-style-type: none"> • Ашиглалтын хэлтсүүд • Гол гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий хог хаягдлыг цуглуулж шилжүүлэх журам • Ажлын байрны үзлэг шалгалт
WM02	Хог хаягдлын ангилалт	<p>Дараахь шалгуур үзүүлэлтийн дагуу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн журам, удирдамж, тодорхойлолт, аргачлалын дагуу бүх хог хаягдлыг ангилна. Үүнд:</p> <p>a) Эрдэст хаягдал (урвалд орохгүй, задарч шингэхгүй элс г.м хаягдлыг багтаасан),</p> <p>b) Аюулгүй хог хаягдал (ахуйн хог хаягдлыг багтаасан),</p> <p>c) Аюултай хог хаягдал (эмнэлэгийн хог хаягдлыг багтаасан).</p> <p>d) Бохир ус (Усны удирдлагын төлөвлөгөөнд орсон).</p>	<ul style="list-style-type: none"> • Ашиглалтын хэлтсүүд • Гол гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий хог хаягдлыг цуглуулж шилжүүлэх журам • Ажлын байрны үзлэг шалгалт
WM03	Хог хаягдлын ангилалт болон хадгалалт	<p>Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цаашдын боловсруулалт, тээвэрлэлт болон зайлуулах хүртэл аюулгүй байдлаар битүүмжилж, мониторинг хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Ашиглалтын хэлтсүүд • Гол гэрээт гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий хог хаягдлыг цуглуулах болон шилжүүлэх журам • Ажлын байрны үзлэг шалгалт
WM04	Орон нутгийн хог хаягдлын дахин боловсруулалт	<p>Мод, дугуй, хаягдал төмөр, картон хайрцаг зэрэг бүтээгдэхүүнийг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийн талаар орон нутагтай зөвшилцөж хэлэлцэнэ.</p> <p>Орон нутгийн иргэд Оюу толгойн дахин боловсруулах материал байрладаг талбай руу нэвтрэх эрхийг Ханбогдод байрлах офист бүртгүүлж авдаг. Үүний тулд Оюу толгой төслийн ажилчидтай адил аюулгүй ажиллагааны сургалтанд (Таницуулга-зааварчилгаа, уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын аюулын дүн шинжилгээ г.м) хамрагдаж, зохих хувийн хамгаалах хэрэгслээрхангагдсан байна. Орон нутгийн иргэдтэй харьцах ажилтан нь нэвтрэх эрх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг удирдан талбай руу хөтөлнө. Газар хөндөх зөвшөөрлийн дагуу, энэ талбайд түр ашиглаж дууссаны дараа зохих нөхөн сэргээлтийг хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Бүсийн хөгжил, нийгмийн үйл ажиллагааны хэлтэс • ЭМААБО-н хэлтэс 	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын тэмдэглэл • Улирлын болон жил тутмын байгаль орчны тайлан

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : OT-10-E7-PLN-0001-M	Хувилбар: 1.1

№	Сэдэв/ талууд	Хэрэглээ/ үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулалт
WM05	Гэрээт гүйцэтгэгчийн хог хаягдлын дахин боловсруулалт	Гэрээт гүйцэтгэгчийн (ЭМААБО-н стандарт, тоног төхөөрөмж, тээвэрлэлт) болон байгууламжийн үнэлгээн дээр үндэслэн дахин боловсруулж болох хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлын дахин боловсруулагч гэрээт гүйцэтгэгчид дамжуулан өгнө.	<ul style="list-style-type: none"> • ЭМААБО-н хэлтэс 	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий хог хаягдлыг цуглуулж шилжүүлэх журам • Хог хаягдлыг дахин боловсруулах байгууламжийн үнэлгээ
WM06	Уурхайн талбайгаас гадуур хог хаягдлын зайлуулалт болон боловсруулалт	Төслийн шаардлагыг хангасан хаягдал боловсруулах байгууламж Монгол улсад баригдах хүртэл тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдал дахин боловсруулагч гэрээт гүйцэтгэгчид рүү явуулахаас бусад тохиолдолд хог хаягдлыг уурхайн талбайгаас гадуур хаях, боловсруулахаар гаргахгүй болно.	<ul style="list-style-type: none"> • Гол гэрээт гүйцэтгэгч • Ашиглалтын хэлтсүүд 	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий хог хаягдлыг цуглуулж шилжүүлэх журам • Ажлын байрны үзлэг шалгалт
WM07	Аюулгүй хог хаягдлын зайлуулалт	Холбогдох орон нутгийн хууль журам болон АНУ-ын байгаль орчныг хамгаалах агентлагын Холбооны улсын зохицуулалтын хууль 258-ийн шаардлагын дагуу зөвшөөрч баталсан, зориулалтын хог хаягдлыг газар булаах байгууламжинд л аюулгүй хог хаягдлыг хаяна. Барилгын үе шатанд ашигласан хог хаягдлыг булшлах түр байгууламжинд хадгалсан хог хаягдлыг байнгын хаягдал булшлах байгууламжинд шилжүүлнэ. Түр байгууламжинд бохирдлын үнэлгээ хийх ба хүний эрүүл мэнд болон байгаль орчин эрсдэл учруулж болох материалын бохирдлоос сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын удирдлагын төвийн инженерийн зураг төсөл • Хог хаягдлын удирдлагын төвийн ашиглалтын журам
WM08	Аюултай хог хаягдлын шатаалт	Европын холбооны удирдамж № 2000/76/ЕС шаардлагад нийцсэн аюултай хаягдлыг шатаах зориулалттайгаар зураг төсөл нь хийгдэж батлагдсан шатаах зууханд зөвхөн аюултай хог хаягдлыг шатааж зайлуулна. Ялангуяа, шатаах зуухнаас ялгарч байгаа хийн температур нь тогтмол хэмжигдэж байх ёстой ба хамгийн байгадаа 2 секунд тутамд хамгийн багадаа 850 °С аүртэл асч байх ёстой.	<ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын удирдлагын төвийн инженерийн зураг төсөл • Хог хаягдлын удирдлагын төвийн ашиглалтын журам

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : OT-10-E7-PLN-0001-M	Хувилбар: 1.1

№	Сэдэв/ талууд	Хэрэглээ/ үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Баталгаажуулалт
WM09	Боловсруулах боломжгүй аюултай хог хаягдал	Зориулалтын болон батлагдсан боловсруулах ба хаях арга, аргачлал одоогоор байхгүй аюултай хог хаягдлыг зохих боловсруултын болон хаях арга чиглэл тодорхой болтол уурхайн талбайд зохих ёсоор хадгална.	<ul style="list-style-type: none"> Дэд бүтцийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлын удирдлагын төвийн ашиглалтын журам Аюултай материалын удирдлагын журам
WM10	Хог хаягдлын тоо бүртгэл	Үүссэн хог хаягдал (жилийн хэмжээнд хуримтлагдсан нийт тоо дүн), уурхайн талбайгаас гадуур дахин боловсруулахаар явуулсан хог хаягдал, боловсруулалт хийхээр төлөвлөсөн аюултай хог хаягдал, аюулгүй хог хаягдал болгон хаясан хог хаягдал болон дахин боловсруулах боломжгүй учраас хадгалж буй аюултай хог хаягдлын талаар байршил тус бүрээр бүртгэл хөтлөх.	<ul style="list-style-type: none"> ЭМААБО-н хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны улирлын болон жилийн тайлан
WM11	Хог хаягдал зайлуулалт	Хатуу хог хаягдлыг (аюултай болон аюулгүй) ил задгай шатаахыг хориглоно.	<ul style="list-style-type: none"> ЭМААБО-н хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Хог хаягдлын удирдлагын төвийн ашиглалтын журам
WM12	Аюултай асгаралтыг цэвэрлэсэн материал	Алгаралтыг цэвэрлэсэн материал болон асгаралтаар бохирлогдсон хөрс нь WM02-д тодорхойлогдсоны дагуу адил шалгуураар ангилагдана. Ландфарм дээр амжилттай цэвэршүүлэгдсэн хөрс нь (нүүрс-устөрөгчөөр бага бохирлогдсон) Ландфармын ашиглалтын журам (OT-10-E7-PCR-0003)-нд заасан зориулалтын талбай руу зөөвөрлөгдөнө. Ландфарм болон бусад цэвэрлэх аргаар цэвэрлэгдэх боломжгүй (нүүрс-ус болон химийн бодисоор их бохирлогдсон) хөрсийг WM09-д тодорхойлсны дагуу хадгална.	<ul style="list-style-type: none"> Дэд бүтцийн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Ландфармын ашиглалтын журам Ердийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх журам Хог хаягдлын удирдлагын төвийн ашиглалтын журам Аюултай материалын удирдлагын төлөвдөгөө

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

6.1. Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэл

Энэ удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутамд, үйл ажиллагааны болон байгаль орчны нөхцөл байдлаас хамааран илүү ойр давтамжтайгаар хянаж шинэчилж байна. Энэ удирдлагын төлөвлөгөөг хянах, шинэчлэх үүрэг хариуцлагыг энэ төлөвлөгөөг хариуцсан албан тушаалтан буюу ЭМААБО хариуцсан хариуцсан Оюу Толгойн ерөнхий менежер хүлээнэ.

Үйл ажиллагааны журманд бодит өөрчлөлт хийх шаардлагатай бол (Оюу Толгойн ЭМААБО-ын удирдлагын системийн Өөрчлөлтийн удирдлагын журмын дагуу тодорхойлсон байна) энэ удирдлагын төлөвлөгөөг “ шаардлагын дагуу” шинэчлэн өөрчилнө.

Удирдлагын төлөвлөгөөний шинэчлэгдсэн хувилбар нь төслийн бүх ажилчдын хэрэгцээнд зориулагдаж Оюу толгой портал сайт дээр тавигдаж байна.

7. МОНИТОРИНГ

7.1. Мониторингийн шаардлагын тойм

Ашиглалтын үе шатанд төслийн стандартуудыг хэрхэн биелүүлж байгааг үнэлэх мониторингийн арга хэмжээг энэ хэсэгт (Хэсэг 4: Төслийн стандартууд-г үзнэ үү) тодорхойлсон.

Мониторингийн явцад төслийн стандартуудыг биелүүлэхгүй байгаа зөрчлийг илрүүлсэн тохиолдолд, эдгээрийг магадлан шинжилж, холбогдох засаж сайжруулах арга хэмжээг тодорхойлно (ОТ БОЭМАА-МС-ийн Элемент 14, Үл нийцэл, осол зөрчлийн удирдлагаийг үзнэ үү).

7.2. Гүйцэтгэлийн гол үзүүлэлт

Энэ удирдлагын төлөвлөгөөний явц, үр дүнтэй байдлыг үнэлэхэд ашиглах гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд болон холбогдох гол мониторингийн үйл ажиллагааг доорх хүснэгтэнд хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 3. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

№	ГҮҮ	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
WM-KPI 01	Хог хаягдалтай холбоотой мэдээлэгдсэн аливаа зөрчлийн тоо	Энэ төлөвлөгөөг зөрчсөн зөрчлийн тоог хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулж, тасралтгүй сайжруулж байх.	Хог хаягдалтай холбоотойгоор жилийн хугацаанд мэдээлэгдсэн аливаа зөрчлийн тоо
WM-KPI 02	Үүссэн хог хаягдлын болон Хог хаягдлын удирдлагын төв рүү явуулсан хог хаягдлын хэмжээ	Хогны хэмжээг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулж, үргэлжлүүлэн сайжруулах.	Нэг хүнд ноогдох сар бүрийн аюулгүй хог хаягдлын хэмжээ
WM-KPI 02	Дахин боловсруулсан хог хаягдлын хувь хэмжээ	Булшилж устгах хог хаягдлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулж, үргэлжлүүлэн сайжруулах.	Дахин боловсруулж болох хог хаягдлын хувь хэмжээ (жишээ нь хуванцар)

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : OT-10-E7-PLN-0001-M	Хувилбар: 1.1

№	ГҮҮ	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
WM-KPI 04	Орон нутгийн иргэдээс хүлээж авсан гомдлын тоо	Хог хаягдалтай холбоотой орон нутгийн иргэдээс хүлээж авсан гомдлын тоог хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулж, үргэлжлүүлэн сайжруулах. Зорилт = тэг	Жилд орон нутгийн иргэдээс хүлээж авсан хог хаягдалтай холбоотой гомдлын тоо (Орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжлийн Гомдол барагдуулах удирдлагаийг системд бүртгэгдсэнээр).
WM-KPI 05	Уурхайн талбайгаас гадуур тогтоосон бохирдлын тохиолдол	Хог хаягдлын удирдлагын төв болон хог хаягдал булшлах түр байгууламжийн эргэн тойрны гүний усны суурь үзүүлэлтийн нөхцлийг хэвээр хадгалах. Зорилт = тэг гүний усны байгалийн өөрчлөлтөөс бусад суурь үзүүлэлтийн нөхцлөөс хэтэрсэн тохиолдол (жнь: Монголын хууль болон таслийн стандартыг хэтэрсэн тохиолдол)	Гүний усны мониторингийн төлөвлөгөөний дагуу Хог хаягдлын удирдлагын төвийн мониторингийн худгуудад шинжилгээ хийх. Усны мониторингийн төлөвлөгөө нь гүний усны суурь үзүүлэлтийн нөхцөлд гарсан өөрчлөлтийг тодорхойлж, цаашдын шинжилгээ болог боломжит өууруулах үйл ажиллагааг тодорхойлдог.
WM-KPI 06	Түр хаягдал булшлах байгууламжийн гүний усны үзүүлэлтүүдийн түвшин	Түр хаягдал булшлах байгууламжийг хаасны дараа гүний усны энхны суурь үзүүлэлтийн нөхцлийг сэргээх. Зорилт= Мониторингийн худгуудын усны чанарт холбогдох бүс нутгийн гүний усны мониторингийн тоо баримтаар баталгаажсан 3 болон түүнээс олон хэмжилтийн бүх үзүүлэлтээр урт хугацааны өөрчлөлт ороогүй байх (нэмэлт мэдээллийг Усны мониторингийн төлөвлөгөөний 6.3 хэсгээс харна уу)	Гүний усны мониторинг болон анализ - иж бүрэн үзүүлэлт – Усны мониторингийн төлөвлөгөөний дагуу түр хаягдалд булшлах байгууламжийн мониторингийн худагт. Тэмдэглэл: Мониторингийн худаг одоогоор өрөмдөгдөөгүй байгаа (2013оны 7-р сар) – 2013 оны өрөмдлөгийн хөтөлбөрт багтсан. Худгийн гүн нь гүний усанд хүрснийг баталж, ойролцоогоор 50м байна.

7.3. Мониторингийн гол үйл ажиллагаа

Ашиглалтын үе шатанд төслийн стандартыг (Хэсэг 4-г харна уу) хэрэгжүүлж мөрдөж буйг шалгах мониторингийн арга хэмжээг доор хүснэгт 4-т тодорхойлсон болно. Мониторингийн үр дүнд төслийн стандартыг зөрчиж байгааг илрүүлсэн тохиолдолд эдгээрийг зөрчил бүрээр нь бүртгэж, магадлан шинжилж, засаж залруулах үйл ажиллагааг тодорхойлно (дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, аюулгүй ажиллагааны удирдлагын төлөвлөгөөний бичиг баримтуудыг үзнэ үү).

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : OT-10-E7-PLN-0001-M	Хувилбар: 1.1

Хүснэгт 4. Мониторингийн гол хэмжилтүүд

№	Сэдэв/Талууд	Параметр	Аргачлал	Давтамж	Байршил	Тайлбар
WMM1	Хог хаягдлын бүртгэл	Жилийн хог хаягдлын хэмжээ болон төрөл (нийт үлдэгдлийг оролцуулан)	Үүссэн хог хаягдал (жилийн хэмжээнд хуримтлагдсан нийт тоо дүн), уурхайн талбайгаас гадуур дахин боловсруулахаар явуулсан хог хаягдал, боловсруулалт хийхээр төлөвлөсөн аюултай хог хаягдал, аюулгүй хог хаягдал болгон хаясан хог хаягдал болон дахин боловсруулах боломжгүй учраас хадгалж буй аюултай хог хаягдлын талаар байршил тус бүрээр бүртгэл хөтлөх.	Улирал тутам	ҮХ	Оюу Толгойн Байгаль орчны хэлтэс
WMM2	Ажлын байрны үзлэг шалгалт	ҮХ	Тухайн хэсгийг хариуцсан ЭМААБО хариуцсан ахлах ажилтнууд/менежерүүд өдөр тутмын шалгалт үзлэгийг хийнэ.	Өдөр тутам	Ажлын бүх гол байруудад	-
WMM3	ЖДҮ-ийн үзлэг шалгалт	ҮХ	Байгаль орчны хэлтсийн тухайн хэсгийг хариуцсан мэргэжилтэн Байгаль орчны шалгалтын хуудсыг ашиглан тогтмол үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Аливаа зөрчлийг Осол зөрчлийн удирдлагын системд мэдээлж байна.	Сар бүр	Ажлын бүх гол байруудад	-
WMM4	Гуравдагч талын баталгаажуулалтын үнэлгээ	ҮХ	Уурхайн талбайгаас гадуур дахин боловсруулахаар явуулсан хог хаягдал ашигласан аливаа гуравдагч гэрээт гүйцэтгэгч, түүний	Гэрээ байгуулах үеэр болон дараа нь тогтмол.	Гуравдагч хог хаягдлын гэрээт гүйцэтгэгчийн байгууламжууд	-

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

№	Сэдэв/Талууд	Параметр	Аргачлал	Давтамж	Байршил	Тайлбар
			байгууламжуудад аудит хийнэ.			
WMM5	Байгаль орчны мониторинг	Метан	Оюу Толгой төсөл нь Хог хаягдлын удирдлагын төв болон хаагдсан хаягдал булшлах түр байгууламжийн эргэн тойронд метаны түвшинд мониторинг хийж гүйцэтгэнэ	Жил бүр	Хог хаягдлын удирдлагын төв болон хог хаягдал булшлах түр байгууламж	Усны мониторингийн төлөвлөгөөний хүрээнд
WMM6	Байгаль орчны мониторинг	Гүний ус	Оюу Толгой төсөл нь Хог хаягдлын удирдлагын төв болон хаагдсан хаягдал булшлах түр байгууламжийн эргэн тойрны гүнийн усны мониторинг хийж гүйцэтгэнэ	Жил бүр	Хог хаягдлын удирдлагын төв болон хаягдал булшлах түр байгууламж	Гүний усны мониторингийн төлөвлөгөөний хүрээнд
WMM7	Байгаль орчны мониторинг	Аюултай хог хаягдлыг шатаах зуух	Аюултай хог хаягдлыг шатаах зуухны агаарын хийн хаягдалд Оюу Толгойн зүгээс мониторинг хийх	Шатаах зуухны ашиглалтын явцад үргэлжилнэ	Аюултай хог хаягдлыг шатаах зуух	Агаарын хийн хаягдлын мониторингийн хүрээнд

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

8. СУРГАЛТ

8.1. Тойм

Бүх сургалтын агуулгыг танилцуулга сургалт (аюулгүй ажиллагааны танилцуулах сургалт)-ын хэсэг болгон оруулж өгсөн ба шаардлагатай тохиолдолд ажлын байрнаас шалтгаалах нэмэлт сургалтуудыг явуулдаг.

8.2. Танилцуулга сургалт

Оюу Толгой төслийн талбай дээр ажиллаж байгаа гол болон бүх гэрээт компанийн ажилчдыг ерөнхий танилцуулга болон ажлын байртай холбоотой танилцуулга, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны талаар гол ойлголт өгөх сургалтанд хамруулж, эрдсийн бус хаягдлын удирдлагын талаар тусгай мэдлэг олгоно.

8.3. Ажлын байран дахь тусгай сургалт

Оюу Толгойн хог хаягдлын удирдлагын үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байгаа бүх ажилчдад ажлын байрны аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол өгнө. Үүнд хог хаягдлын зохистой удирдлагын болон хог хаягдлыг ангилах, ялгах талаар дэлгэрэнгүй мэдээлэл багтан орсон байна.

Хог хаягдлыг тээвэрлэх гэрээт гүйцэтгэгчдэд зохих сургалтыг өгч, тээвэрлэлтийн явцад хог хаягдал болон дахин боловсруулах хог хаягдлыг санамсаргүйгээр асгаж, хаяхаас урьдчилан сэргийлсэн байдлаар тээвэрлэлтийг хийж гүйцэтгэнэ.

8.4. Сургалтын бусад шаардлагууд

Хог хаягдлыг ялгах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах үйл ажиллагаанд оролцдог гол гол ажилтнууд болон үйлдвэрийн операторуудад нэмэлт, тусгайлсан сургалтыг өгнө.

Ямар хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, газарт булах болон шатаах талаар нарийвчилсан мэдээллийг хаягдал булшлах байгууламж болон хаягдал шатаах зуухны операторуудад өгөхийн тулд хог хаягдлыг ангилах чиглэлийн сургалтыг зохион байгуулна.

Шаардлагатай бол, онцгой байдлын үед авах арга хэмжээнүүдийн хувилбаруудын талаар мэдлэг, ур чадварыг олгоно.

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

9. АУДИТ БОЛОН ТАЙЛАН

9.1. Дотоод аудит

Өдөр тутмын үзлэг шалгалтыг тухайн үйл ажиллагааны салбарын ЭМААБО хариуцсан ахлах ажилтан/ахлах мэргэжилтэн ЭМААБО-ны чиглэлээр өргөн хүрээг хамруулан гүйцэтгэнэ. Мөн тогтсон хуваарьт үзлэг шалгалтыг ЭМААБО-ны хэлтсээс гардан Байгаль орчны хяналт шалгалтын хуудсыг ашиглан гүйцэтгэнэ.

Эдгээр хяналт шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийг зөрчлийн удирдлагын системд бүртгэж оруулна (14-р элемент).

Хуулийн нийцтэй байдал нь элемент 16-Гүйцэтгэлийн үнэлгээ, аудитийн дагуу Дотоодын жилийн аудитын хөтөлбөрийн дагуу шалгагддаг. Энэ нь ЭМААБО-ны удирдлагын системийн (БОННБНУ болон удирдлагын төлөвлөгөөнүүдийг хамруулаад) шаардлагад нийцсэн эсэхийг үнэлэх зорилготойгоор хийгддэг.

Эдгээр хяналт шалгалтаар илэрсэн аливаа хуулийн нийцэмжгүй байдал болон зөрчил нь Байгаль орчны БОНМТ-ний баримтанд тодорхойлогдсон Оюу толгойн ЭМААБО-ны Удирдлагын системийн шаардлагын дагуу бүртгэгдэнэ.

9.2. Гадаад аудит

Рио Тинто корпорацийн ЭМААБО бизнесийн нийцэмжтэй байдлын аудитын хөтөлбөр болон төслийн зээлдэгчид нь энэ төлөвлөгөөний нийцэмжтэй байдалд тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлгээ хийж байна.

9.3. Бүртгэл хөтлөлт

Аудит, үзлэг шалгалт, осол зөрчлийн бүртгэл нь Элемент-8 Баримт бичиг ба баримт бичгийн хяналт болон Элемент-15 Тоо мэдээллийн бүртгэлийн Удирдлагын дагуу зохицуулагдана.

Рио Тинто Бизнес солушин программ нь дотоод болон гадаад аудитаар илэрсэн үл нийцтэй байдал болон холбогдох арга хэмжээ мөн Зөрчил болон холбогдох судалгаа, арга хэмжээг бүртгэдэг.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар : ОТ-10-Е7-PLN-0001-М	Хувилбар: 1.1

10. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ

Файлын нэр	ОТ-10-Е7-PLN-0001-М- Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө
Эхийг зохиогч	Айван Велла, Хангамж ба Дэд бүтцийн хөгжлийн
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	#

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Дунд	2013.09.01	Химийн бодис ба хог хаягдлын удирдлагын баг	2 жил бүр	2015.09.01

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	Химийн бодис ба хог хаягдлын удирдлагын баг	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баримт бичгийн дугаарлалтыг засч, баримт бичгийг хянав.